

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2020 оны 5 дугаар сарын 27-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: Дизель хөдөлгүүртэй ачааны автомашин нийлүүлэх

Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/202004414

“Монголросцветмет” ТӨҮГ эрх бүхий тендерт оролцогчдоос “Дизель хөдөлгүүртэй ачааны автомашин нийлүүлэх” тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг www.tender.gov.mn цахим хуудсаар дамжуулан эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь **50,000.00 /тавин мянган/** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна:

Борлуулалтын хэмжээ: **2018, 2019 оны аль нэгд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 100%-иас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 100%-иас багагүй байна.**

2018, 2019 оны санхүүгийн тайланд хийсэн Аудитын байгууллагын дүгнэлтийн эх хувь, эсвэл нотариатаар баталгаажуулсан хуулбар хувийг ирүүлэх бөгөөд санхүүгийн тайланг бүгдийг ирүүлэх шаардлагагүй.

Тендерийн хамт 1,600,000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2020 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 10:00 цагаас өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба мөн өдрийн 10:10 цагт цахим системээр нээнэ.**

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **Зөвшөөрөхгүй.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх. **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, БЗД-22, Энхтайваны өргөн чөлөө – 98, 406 тоот өрөө, утас: 450060 + 115

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ